

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 09 сарын 28 өдөр

Дугаар А/28

Арвайхээр

Ёс зүйн зөвлөл байгуулах тухай

Монгол улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн 6.1, 6.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 129 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам”-ын 2.1, 2.2, 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн газрын “Ёс зүйн зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Байгууллагын албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр жилийн ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллахыг Ёс зүйн зөвлөлийн дарга (Я.Жаргал)-д даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Удирдлага төлөвлөлтийн хэлтэсийн дарга (Н.Оюунтуяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ШИВААННҮРДЭВ

18900 095

Эрүүл мэндийн газрын даргын
2021 оны 09 дүгээр сарын 28-ны
өдрийн 4 дугаар тушаалын
хавсралт

ИЧЭӨ0007

ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ёс зүйн зөвлөлийн дарга

Я.Жаргал, ХШҮМХ-ийн дарга

Нарийн бичгийн дарга

П.Оюунбилэг, УТХ-ийн мэргэжилтэн

Гишүүд

Ч.Одончимэг, ЭТХ-ийн мэргэжилтэн

М.Мөнхбаатар, Эдийн засагч

Б.Оюунчимэг, НЭМХ-ийн мэргэжилтэн